

Хүүхдэд зориулсан Библи
танилцуулж байна

Дөчин
ЖИЛ



Зохиогч: Edward Hughes

Зураглаач: Janie Forest

Найруулсан: Lyn Doerksen


Орчуулсан: Damdin Norolsuren

Бүтээсэн: Bible for Children
www.M1914.org


©2014 Bible for Children, Inc.


**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах
эрхтэй харин худалдахыг хориглоно.**







Бурхан Израилийн ард
түмнийг Египетээс авран
гаргаснаас хойш Мосе
тэднийг мөргөл хийхээр
дагуулан явав. Тэр
магтаалын дуу
ЗОХИОВ.





Мосе "Би ЭЗЭНд дуулья.
Учир нь Тэр өндөрт
өргөмжлөгджээ" хэмээн
Бурхан Израилийн төлөө
хийсэн бүх агуу зүйлсийг
магтан дуулсаар
явлаа.





Гурван өдөр аялсны
дараа цангасан олон
усан сан олжээ. Гэвч
ус шорвог байсан тул

ТЭД УС

УУЖ ЧАДСАНГҮЙ.




**Тэд залбирахын оронд
гомдоллов. Бурхан бол
энэрлээр дүүрэн билээ.**



**Тэр тэдэнд
зориулж сайн
ус гаргаж өгөв.**





**Ард түмэн бүх
зүйлд гомдоллож
байв. Тэд "Бид Египетэд байхдаа
хоол хүнсээр дутаагүй.**






**Энэ
цөлд бид
өлсөж
үхэх нь“**


хэмээн хашхирч байв.

**Тэр орой Бурхан бөднө шувууг
хоол болгон явуулав. Ард түмэн
тэднийг амархан барьж байлаа.**




**Дараа өглөө нь Бурхан маннаг
хоол болгон өгөв.
Манна бол зөгийн
балын амттай нэг**

**төрлийн
талх юм.**




**Өглөө бүр манна газрын хөрсөн
дээр түүхэд бэлэн
гарч ирдэг байв.
Цөлд ийм замаар**




**Бурхан
өөрийн
хүмүүсийг
тэжээж
байлаа.**




**Тэд өглөө бүр Бурхан шинэ
хоол хүнс гаргана ХЭМЭЭН
найддаг байлаа.**




**Бурхан илүү хурааж авч болохгүй
гэсэн ч зарим хүмүүс авах ёстой
ХЭМЖЭЭНЭЭСЭЭ
ИЛҮҮГ хураав.**



**Амралтын өдрийн өмнөх өдрөөс
бусад өдөр илүү хурааж авсан манна
өглөө болоход өтөөр дүүрдэг байв.**



Учир нь амралтын өдөр хүмүүс
амрах ёстой тул өмнөх өдөр нь
хангалттай хураадаг байв.



Бурхан цөлд
Израйлийн
ард ...



**... ТҮМНИЙГ
бүх талаар
ХАЛАМЖИЛЖ
байв.**



**Тэр уух ус, идэх
хоолоор хангаж
бас тэнийг
дайснуудаас
нь
хамгаалж
байв.**



**Амеллекчүүд дайрах
үед Мосе Бурханы
өгсөн савааг
дээш өргөх
тусам ялж
байв.**





**Бурхан Израилийн
ард түмэнд "Хэрэв та нар
миний дууг сонсож дуулгавартай
дагавал миний онцгой ард
түмэн болох болно" гэв.**





Ард түмэн Мосед

"Бурханы айлдсан болгоныг бид дагах болно" гэлээ. Тэд Синай уулан дээр ирээд Мосе Бурхантай уулзахаар дээш гарав.





**Мосе уулан дээр
Бурхантай
хамт дөчин
өдөр байв.
Бурхан
түүнд
арван
хуулийг
бичсэн хоёр
чулуун хавтанг
өгөв.**





**Бурхан өөрийн
хүмүүсээ
хэрхэн
амьдраасай
гэж хүсэж
буйгаа
түүнд
хэлэв.**



1. "Та нар
Надаас өөр
Бурхантай
байж
болохгүй."

2. "Хиймэл
шүтээнд бүү
мөргө."

3. "Бурхан
Эзэнийхээ
нэрийг дэмий
бүү дурд."



**4. "Амралтын
өдрийг
ариунаар
сахь."**

**5. "Эцэг эхээ
хүндэл."**



6. "Хүн
бүү ал."


7. "Бүү
завхайр."

8. "Бүү
хулгай хий."

9. "Худлаа
бүү хэл."


10. "Бүү
шунхайр."





**Синай
ууланд Мосе
Бурхантай
ярилцаж
байх хойгуур
Израилийн
ард ТҮМЭН
НҮГЭЛ ҮЙЛДЭВ.**





**Тэд Ааронд алтан
тугал цутган хий
гэж тушаагаад
түүндээ Бурханы
оронд мөргөл
үйлджээ. Бурхан
маш ихээр
хилэгнэв. Мосе ч
бас ихэд уурлав.**





**Мосе алтан тугал
болон түүнийг
тойрон бүжиглэж
байсан хүмүүсийг
хараад хууль
бичсэн чулуун
хавтанг газар
шидэж хагалав.**






**Мосе алтан
хиймэл
шүтээнийг
ууртайгаар
эвдэв. Бас
үүнд мөргөл
үйлдэж байсан
хүмүүсийг
алав.**





**Бурхан чулуун
хавтанг дахин
бэлдэн өгөв. Тэр
Мосед том асар барьж
тойруулан хашаа барь гээд
тэнд би өөрийн
хүмүүстэйгээ
уулзах
болно
гэлээ.**



**Тэд тэнд Бурханд
зориулж мөргөл
үйлддэг болжээ.**

**Бурхан үүлэн багана болон
галан баганаар өөрийн
бууж ирснээ
мэдэгддэг
байлаа.**



Тэд канаан нутагт дөхөж ирэхэд
Мосе арван хоёр хүнийг туршуулаар
Бурхан өөрийн хүмүүстээ амласан
газрыг тагнуулахаар явуулжээ.



**Туршуулууд бүгд сайхан газар байна
гэсэн боловч тэднээс Иошуа болон
Калев гэгдэх ...**



**... хоёр хүн л энэ газрыг эзлэн авахад
Бурхан туслах болно гэдэгт итгэж
байлаа.**



**Бусад арван туршуул
тэр газарт нутаглаж
байсан том хүчтэй
улсуудаас
айж байв.**


**Тэд "Бид
ЭНЭ нутгийг
ЭЗЭЛЖ чадахгүй"
ХЭМЭЭН хашхирч байв.**



**Тэд Бурхан тэднийг
Египетээс
чөлөөлсөн
гэдгийг
мартжээ.**





**Ард түмэн итгэл муутай арван
туршуулыг
үгэнд
итгэв.**




**Тэд уйлан Египет уруу буцахаар
зэхэж байлаа. Тэд
бас Мосег алах
гэж оролдов.**



**Бурхан Мосег аварчээ. Тэгээд тэр
ард түмэнд хандан "Дөчин жил та
нар эргэлзсэн.**



**Зөвхөн Калев, Иошуа болон та
нарын хүүхдүүд л тэр нутагт
орох болно
гэлээ."**



Дөчин жил

Бурханы үг Библиээс авсан түүх

Египетээс гарсан нь 15 ~ Тооллого 14

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Төгсөв



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг
бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж
хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж
хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь
үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир
Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн
өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг
зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс
дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та
Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал
гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр
таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн
та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



**Хэрвээ та энэ үнэнд итгэж
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө
амьдрахад туслаач. Амен.**

**Библи уншиж өдөр бүр Бурхантай
ярилцаарай! Иохан 3:16**

